

1- р сар

- I. Сумдын төвийн товч мэдээлэл
- II. Суурин хүн амын тоо
- III. Төсвийн орлого
- IV. Төсвийн орлого, /сумаар/
- V. Төсвийн зарлага
- VI. Банкны кассын орлого зарлага, зээл хадгаламж
- VII. Ажил хайгч иргэд
- VIII. Бүртгэлтэй ажилгүйчүүд, ажлын байрны зуучлал
- IX. Нийгмийн даатгалын орлого, зарлага
- X. Нийгмийн даатгал заавал даатгуулагчийн тоо
- XI. Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
- XII. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- XIII. Хэрэглээний үнийн индекс
- XIV. Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ
- XV. Аж үйлдвэр
- XVI. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
- XVII. Нийгмийн халамж
- XVIII. Гэмт хэргийн мэдээ
- XIX. Гэмт хэрэг зөрчил (сумдаар)

Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2019 оны 1-р сарын байдлаар)

I. Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2020 оны 1-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 33 хувьтай буюу 660.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 113.8 хувьтай буюу 118.4 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 814.6 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 38.1 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 9658.2 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 84.4 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 2283.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 2414.2 сая төгрөг, төсвөөс санхүүжих 3161.1 сая төгрөг, аймгаас авсан татаас 1138.2 нийт 8997.4 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Хулд сумаас бусад бүх сумд 13.6-244.7 хувиар буюу 2.3-17.6 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн бол Хулд сум 6.2 хувиар тасалдуулсан байна.

II. Төсвийн зарлага



2020 оны 1 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 4266.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.1 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 2101.1 сая төгрөг болж нийт зардлын 49.2 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 28.6 хувиар өсч 249.9 сая төгрөг болсон байна. Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 27 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 27.9 хувиар, хангамж бараа материалын зардал 6.8 хувиар тус тус өссөн бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, томилолтын зардал, бараа үйлчилгээний

бусад зардал 1.0-64.1 хувиар буюу 2.0-97.1 сая төгрөгөөр буурсан байна.

III. Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд буюу 120908.6 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 703.3 сая төгрөг, чанаргүй зээл 1331.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 16.7 хувиар буурч, чанаргүй зээл 28.6 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1,7 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар өсч 65498.9 сая төгрөг болов.


IV. Хүн ам



Аймгийн суурин хүн амын тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 46437 болж, өмнөх оноос 383 хүнээр буюу 0.82 хувиар буурсан байна. Нийт хүн амын 49.7 хувийг эмэгтэйчүүд, 50.3 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна.



Аймгийн Хүн амын нас хүйсийн суваргаас харвал нийт хүн амын дүнд 0-14 насны хүүхэд 30.4 хувийг, 65-аас дээш насны өндөр настан 4,7 хувийг тус тус эзэлж байна.



Аймгийн хүн амыг байршилаар нь авч үзвэл аймгийн нийт хүн амын 55 хувь буюу 25585 хүн нь хөдөөд, 27 хувь буюу 12379 нь аймгийн төвд, 18 хувь буюу 8473 нь сумын төвд амьдарч байна. Өрх: Аймгийн өрхийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 14863 болж өмнөх онтой харьцуулахад 669 өрхөөр буюу 4.5 хувиар буурсан байна.

V. Бүртгэлтэй ажилгүйчүүд



2020 оны 1 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 273 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 60.9 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 52 хувь буюу 142 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 84 ажил хайгч иргэн ногдож байхад Говь-Угтаал 325, Цагаандэлгэр 111, Баянжаргалан 117, Гурвансайхан 173, Эрдэнэдалай 250, Дэлгэрхангай 127, Сайхан-Овоо 199 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

Ажлын байрны зуучлал

ХХҮГазрын 2020 оны 1 сарын мэдээгээр нийт 73 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 53 хүнээр өссөн

байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 5.5 хувь, боловсролын салбарт 1.4 хувь, үйлчилгээний бусад салбарт 60.3 хувь, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 1.4 хувь, төрийн удирдлага ба батлах хамгаалах үйл ажиллагааны салбарт 31.4 хувь зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 53 нь буюу 72.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

VI. Нийгмийн халамж



2020 оны эхний 1 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 3908 хүнд 349,2 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 56,1% буюу 2192 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүд болон олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, жирэмсэн эмэгтэйчүүдэд 105,3 сая төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 928 иргэнд 90,5 сая төгрөг, Халамжийн тэтгэврийг 717 иргэнд 145,1 сая төгрөгийг бусад төрлийн тусламж үйлчилгээнд 71 иргэнийг хамруулан 8,1 сая төгрөгийг зарцуулжээ.

VII. Нийгмийн даатгал



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 1 сарын байдлаар 5569.1 сая төгрөг, зарлага 2932.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 922.4 сая төгрөгөөр, зарлага 358.4 сая төгрөг буюу 13.9 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2020 оны 1 сарын байдлаар 3532 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 444 хүн буюу 12.6 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 934 хүн буюу 26.4 хувь нь төсөвт байгууллагаас, 2154 хүн буюу 61.0 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сайн дурын даатгуулагч, аж ахуй нэгж, байгууллага даатгуулагч өсч, төсөвт байгууллагын даатгуулагч буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2020 оны 1 сарын байдлаар 2523.5 сая төг болж, үүний 84.7 хувийг өндөр настны, 9.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй


иргэдийн, 2.7 хувийг тэжээгчээ алдсаны, 3.3 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны 1 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 7157 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 82.8 хувь буюу 5926 хүн өндөр насны, 12.0 хувь буюу 859 хүн тахир дутуугийн, 3.2 хувь буюу 240 хүн тэжээгчээ алдсаны, 1.9 хувь буюу 137 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны 1 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 282 ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 24 ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 17 хүн байна.

1 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 8851 байгаагийн 83.1 хувь буюу 7359 төр хариуцах иргэд, 12.3 хувь буюу 1087 малчид, 3.3 хувь буюу 297 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.2 хувь буюу 108 оюутан суралцагсад байна.

VIII. Эрүүл мэнд

 Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2020 оны 1-р сарын байдлаар 81 эх төрсөн ба нийт 81 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор өссөн байна. Төрсөн эхчүүдийн 87.6 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар эндэгдэл гараагүй байна. Нас баралтын 16 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдлоор буурчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 3 буюу 18.7 хувийг эзэлж 16 хүн нас барсан байна.

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 1363 эмчлүүлэгч хэвтэж, 1215 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 8613 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.1 байна. 2020 оны 1 сарын байдлаар 18135 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 22.8%, амбулаторийн үзлэг 58.5%, идэвхтэй хяналт 12.3%, гэрийн үзлэг 3.5%- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 32.7 хувь нь эрэгтэй, 67.3 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 39 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үетэй адил ба 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 8.4% болж өмнөх оны мөн үеэс 4.7 пунктээр буурсан байна

IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2020 оны 1-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2019 оны 1-р сартай харьцуулахад 7.7 хувиар өсжээ.

Хэрэглээний үнийн индекс 7.7 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 13.4 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 4.8 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 9.9 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 5.5 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 8.3 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 1.2 хувиар, тээврийн бүлэг 1.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

2020 оны 1 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

№	Барааны нэр, төрөл	1/08	1/15	1/22	1/29
1	Гурил, 1-р зэрэг, кг	1290	1290	1290	1290
2	Хонины мах, кг	7500	7500	7500	8000
3	Үхрийн мах, кг	0	0	0	0
4	Ямааны ястай мах, кг	6500	6500	6500	7000
5	Элсэн чихэр, кг	1960	1960	1960	1960
6	Цагаан будаа, кг	2310	2310	2360	2360
7	Шингэн сүү, л	3500	3500	3500	3500
8	Ноолуурын үнэ 1 кг	65000	65000	65000	65000
9	Бензин А-80, 1литр	1810	1810	1810	1810
10	Бензин А-92, 1литр	1920	1920	1920	1920
11	Дизель түлш 1 литр	2490	2490	2490	2490

Х. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2020 оны 1 сарын байдлаар 904.6 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 14.6 хувиар өссөн байна.

ХI. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн 2020 оны 1 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 41 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 64 хувь болж 16 хүнээр өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 80 хувиар буурч 1 хүн холбогдоод байна. 2020 оны 1 сарын байдлаар хүнийг алах, танхайрах, булаалт, албан тушаалын гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс залилан, дээрэмдэх, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэргүүд өссөн байна. Харин малын хулгай, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг буурсан байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 34.2 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 12.2 хувийг бусдын эд хөрөнгийн хулгайн хэрэг, 2.4 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг, 2.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэрэг, 4.8 хувийг дээрмийн хэрэг, 4.8 хувийг хүчингийн хэрэг, 7.3 хувийг малын хулгайн хэрэг, 9.7 хувийг залилангийн хэрэг, 22.2 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 0.2 хувийг бүлэглэж, 0.1 хувийг эмэгтэй хүн оролцон үйлдсэн хэрэг эзэлж байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 14 хүн байхад Баянжаргалан 25, Гурвансайхан 27, Өлзийт 25, Сайнцагаан 23, Цагаандэлгэр 29 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 134.1 сая төгрөг байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 81.6 хувиар буурч 2.5 хувь болсон байна.

ХII. Байгаль орчин



ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сарын агаарын температур нь нутгийн хойд хэсгээр дунджаас дулаан, бусад дунджийн орчим байх төлөвтэй байна.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхний хагаст ихэнх нутгаар шөнөдөө 22-27 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн байна. Харин нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр хүйтний эрч суларна. Мөн гуравдугаар арав хоногийн дунд үеэс хүйтний эрч харьцангуй суларч ихэнх нутгаар шөнөдөө 16-21 градус, өдөртөө 1-6 градус хүйтэн байна. Бусад хугацаанд шөнөдөө 19-24 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байна.

Энэ сард бүх нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна.

Хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр зарим газраар бага зэргийн цас орж, зөөлөн цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй. .

Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлчээр, хоёр болон гуравдугаар арав хоногийн ихэнх хугацаанд зарим газраар 12-14 м/с хүрч ширүүсэх төлөвтэй.

I.СУМДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2020.02.12

Сумд	нутаг дэвсгэр /мян. га-гаар /	Багийн тоо	өрхийн тоо	хүн амын тоо /суурин хүн амаар/	Шилэн кабельд холбогдсон эсэх	малын тоо /мян. тол /	УБ-аас сум хүртэлх зай км	Аймгийн төвөөс сум хүртэлх зай км
Дэлгэрцогт	250.2	3	561	1639	+	199.5	216	44
Дэрэн	362.4	4	608	2118	+	279.0	210	66
Говь-Угтаал	270.7	4	496	1542	+	208.0	240	101
Цагаандэлгэр	342.8	4	398	1017	+	152.4	198	148
Баянжаргалан	318.9	3	454	1261	+	157.3	286	148
Өндөршил	485.2	3	466	1388	+	189.7	356	182
Гурвансайхан	541.6	5	658	2140	+	312.8	300	71
Өлзийт	1542.1	6	752	2360	-	369.8	358	98
Хулд	607	4	717	2372	+	295.8	343	83
Луус	316	3	562	1863	+	193.9	310	50
Дэлгэрхангай	620.9	4	671	2292	+	220.4	357	130
Сайхан-Овоо	405.5	4	660	2111	+	207.0	392	209
Эрдэнэдалай	735.1	7	1663	5806	+	586.1	275	114
Сайнцагаан	340.6	9	4734	15716	+	417.5	260	0
Адаацаг	330	5	794	2812	+	303.5	211	104
Дүн	7469	68	14194	46437	0	4092.7	4312	1548

II. Аймгийн суурин хүн амын тоо, насны бүлгээр, хүйсээр
2020.02.12

Нас, насны бүлэг	Хүн амын тоо		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хүн ам бүгд	46437	23398	23039
0-4 настай	5514	2848	2666
5 настай	994	534	460
6 настай	968	494	474
7 настай	878	445	433
8 настай	797	394	403
9 настай	865	473	392
10-14настай	4105	2109	1996
15 настай	634	324	310
16 настай	734	392	342
17 настай	765	372	393
18 настай	705	371	334
19 настай	743	398	345
20-24настай	3776	1974	1802
25-29 настай	3453	1805	1648
30-34 настай	3491	1790	1701
35-39 настай	3359	1714	1645
40-44 настай	3166	1594	1572
45-49 настай	2803	1384	1419
50-54 настай	2433	1238	1195
55-59 настай	2198	1050	1148
60-64 настай	1589	688	901
65-69 настай	906	386	520
70-74 настай	529	235	294
75-79настай	420	167	253
80-84настай	343	133	210
85-89настай	201	64	137
90-94настай	51	17	34
95-99 настай	15	5	10
100 аас дээш настай	2	0	2

Нийт өрхийн тоо, сумдаар, байршлаар-2019

2020.02.10

Сумд	Өрхийн тоо		Үүнээс		
	2018	2019	Аймгийн төвд	Сумдын төвд	Хөдөөд
Адаацаг	867	794	0	143	651
Баянжаргалан	443	454	0	185	269
Говь-Угтаал	537	496	0	111	385
Гурвансайхан	684	658	0	111	547
Дэлгэрхангай	718	671	0	297	374
Дэлгэрцогт	583	561	0	185	376
Дэрэн	637	608	0	139	469
Луус	579	562	0	198	364
Өлзийт	863	752	0	128	624
Өндөршил	487	466	0	119	347
Сайнцагаан	4868	4734	3724	0	1010
Сайхан-Овоо	692	660	0	209	451
Хулд	742	717	0	256	461
Цагаандэлгэр	397	398	0	193	205
Эрдэнэдалай	1766	1663	0	349	1314
Дүн	14863	14194	3724	2623	7847

III. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

2020.1.10

Үзүүлэлт	мөр	2019 I	2020 I			20/19
			төл	гүйц	хувь	хувь
Нийт орлого /тусламжийн дүн/	1	3629324.0	11437857.1	9658244.9	84.4	266.1
А.УРСГАЛ ОРЛОГО	2	558560.5	1995382.2	660397.3	33.1	118.2
І.ТАТВАРЫН ОРЛОГО	3	297277.1	206550.0	303563.4	147.0	102.1
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	256877.3	184300.0	261608.2	141.9	101.8
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	5	224863.3	170000.0	246195.9	144.8	109.5
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	6	0.0	0.0	0.0	-	-
1.2 Үйл ажиллагааны орлого	7	16175.5	14300.0	15412.3	107.8	95.3
1.3 Хөрөнгө борлуулсаны	8	3924.1	0.0	0.0	-	0.0
1.5 Бусад татвар	9	11914.4	0.0	0.0	-	0.0
2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/	10	5852.6	3090.0	1405.0	45.5	24.0
3. Авто тээврийн хэрэгслийн	11	3885.4	0.0	4034.4	0.0	103.8
4. Бусад татвар	12	30661.8	19160.0	36515.8	190.6	119.1
4.1 Улсын тэмдэгтийн	13	11787.6	9600.0	16395.4	170.8	139.1
4.2 Ашигт малтмал нөөцийн	14	500.0	0	122.3	-	24.5
4.3 Газрын төлбөр	15	9572.5	1260.0	2632.5	208.9	27.5
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	16	263.0	8300.0	894.9	10.8	340.3
4.6 Усны төлбөр	17	8214.7	0.0	15980.7	-	194.5
4.6.Бусад	19	324.0	0.0	490.0	-	151.2
II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20	261283.4	1788832.2	356833.9	19.9	101.6
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	21	128495.4	1716632.2	208260.7	12.1	162.1
2.2 Бусад нэр заагдаагүй	22	132788.0	72200.0	148106.9	205.1	111.5
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	23	0.0	7750.0	466.3	6.0	#DIV/0!
V.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	24	3070763.5	9434724.9	8997381.3	95.4	293.0
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	25	748145.0	2283931.9	2283931.9	100.0	305.3
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	26	2208975.2	2414162.3	2414162.3	100.0	109.3
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих	27	113643.3	337044.0	0	0.0	0.0
Хандив тусламж	28	0.0	25476.6	0	0.0	-
Төсвөөс санхүүжих	29	0.0	3235892.3	3161069.3	97.7	-
Аймаг нийслэлээс авсан татаас	30	0.0	1138217.8	1138217.8	100.0	-
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	31	558560.5	2003132.2	660863.6	33.0	118.3
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	32	2138199.4	2030000.0	2688871.3	132.5	125.8
Аймгийн нийт орлого	33	2696759.9	4033132.2	3349734.9	83.1	124.2

IV.Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Сумд	2020 I			2020 I сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дэлгэрцогт	6250.0	9726.8	155.6	6250.0	9726.8	155.6
Дэрэн	6950.0	9288.2	133.6	6950.0	9288.2	133.6
Говь-Угтаал	71710.0	81464.7	113.6	71710.0	81464.7	113.6
Цагаандэлгэр	3980.0	6374.3	160.2	3980.0	6374.3	160.2
Баянжаргалан	7180.0	24746.0	344.7	7180.0	24746.0	344.7
Өндөршил	8250.0	10561.2	128.0	8250.0	10561.2	128.0
Гурвансайхан	14570.0	19589.2	134.4	14570.0	19589.2	134.4
Өлзийт	10320.0	12639.9	122.5	10320.0	12639.9	122.5
Хулд	13890.0	13034.1	93.8	13890.0	13034.1	93.8
Луус	8820.0	14653.9	166.1	8820.0	14653.9	166.1
Дэлгэрхангай	23070.0	26849.7	116.4	23070.0	26849.7	116.4
Сайхан-Овоо	7120.0	10767.3	151.2	7120.0	10767.3	151.2
Эрдэнэдалай	19760.0	23801.7	120.5	19760.0	23801.7	120.5
Сайнцагаан	40820.0	71474.3	175.1	40820.0	71474.3	175.1
Адаацаг	8460.0	12248.1	144.8	8460.0	12248.1	144.8
Дундговь	171050.0	267708.5	156.5	171050.0	267708.5	156.5
Дүн	422200.0	614927.9	145.6	422200.0	614927.9	145.6

V.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр
2020.01.10

Зарлагын төрөл	2019 I	2020 I			2020 I /2019 I
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Орон нутгийн байгууллагын зарлагын дүн	3134338.5	11194460.7	4266385.3	38.1	136.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1756305.7	2487571.6	2101130.6	84.5	119.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194382.9	333821.5	249886.6	84.5	128.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	509517.9	655277.3	504365.0	74.9	99.0
Хангамж бараа материалын зардал	26477.9	94320.8	28272.5	30.0	106.8
Норматив зардал	47899.3	190960.2	40935.3	21.4	85.5
Эд хогшил урсгал засварын зардал	12992.9	71059.8	16618.8	23.4	127.9
Томилолтын зардал	10007.5	31915.7	7978.4	25.0	79.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	33602.4	119514.0	42679.1	35.7	127.0
Бараа үйлчилгээний бусад зардал	151512.0	1580655.9	54457.1	3.4	35.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.0	27581.4	27581.4	100.0	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг	13366.2	1138217.8	1138217.8	-	8515.6
Бусад урсгал шилжүүлэг	378273.8	189429.5	15497.5	8.2	4.1
Хөрөнгийн зардал	0	1836006.1	8722.6	62.2	-

VI.ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

(Сая.төгрөг,
тоогоор)

2020.02.10

Үзүүлэлт		Үлдэгдэл		2019/2020	
		2019-I	2020-I	хувь	
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл		120964.9	120,908.6	100.0
	Үүнээс:	Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	844.7	703.3	83.3
		Чанаргүй зээлийн үлдэгдэл	933.9	1,331.0	142.5
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл		10960.2	14,083.0	128.5
	Үүнээс:	Иргэдийн харилцахын үлдэгдэл	-	8,266.5	-
	Нийт хадгаламжийн үлдэгдэл		50963.8	65,518.9	128.6
	Үүнээс:	Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	-	65,498.9	-
		Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	9757.2	12,321.2	126.3
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл		41206.6	53,197.7	129.1	
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо		-	34	-
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо		-	169	-
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)		-	21012	-
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		-	85455	-
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		-	33055	-
	Нийт АТМ-ны тоо		-	19	-
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо		-	39732	-

VII.АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2020.02.07

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд	Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд
Дэлгэрцогт	1178	12	1	0	8
Дэрэн	1474	21	0	0	0
Говь-Угтаал	1106	19	36	17	325
Цагаандэлгэр	723	13	8	5	111
Баянжаргалан	858	15	10	3	117
Өндөршил	1027	41	0	0	0
Гурвансайхан	1560	37	27	7	173
Өлзийт	1712	11	1	1	6
Хулд	1697	28	1	1	6
Луус	1331	11	0	0	0
Дэлгэрхангай	1581	22	20	9	127
Сайхан-Овоо	1508	24	30	17	199
Эрдэнэдалай	3954	65	99	59	250
Сайнцагаан	10649	115	37	20	35
Адаацаг	1958	14	3	3	15
Дүн	32316	448	273	142	84

ҮИИ. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2020 оны эхний 01 сарын байдлаар

2020.02.06			
Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	0.0	0.0	0.0
Уул уурхай олборлох үйлдвэр	0.0	0.0	0.0
Боловсруулах аж үйлдвэр	0.0	0.0	0.0
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	0.0	0.0	0.0
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	0.0	0.0	0.0
Барилга	0.0	0.0	0.0
Бөөний ба жижиглэн худалдаа	0.0	0.0	0.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Зочид буудал, зоогийн газар	0.0	0.0	0.0
Мэдээлэл холбоо	0.0	0.0	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4.0	4.0	5.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	23.0	17.0	31.5
Боловсрол	1.0	1.0	1.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.0	1.0	1.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.0	0.0	0.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.0	30.0	60.3
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		0.0	0.0
Бүгд	73.0	53.0	100.0

IX.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА /сая.төг/

2020.02.08

	2019 оны I сар	2020 оны I сар			<u>2020 I</u>
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	<u>2019 I</u> хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	4646.7	1145.3	5569.1	486.3	119.9
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	4233.2	993.7	5088.3	512.1	120.2
Тэтгэмжийн даатгалын сангийн	158.2	81.1	167.3	206.3	105.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	184.2	0.0	193.9	0.0	105.3
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	61.2	58.4	68.7	117.6	112.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	9.9	12.1	50.9	420.7	514.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага	2574.5	2991.5	2932.9	98.0	113.9
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	2226.2	2755.0	2523.7	91.6	113.4
Тэтгэмжийн даатгалын сангийн	88.1	172.1	140.3	81.5	159.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	166.7	0.0	192.4	0.0	115.4
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	59.4	12.3	39.1	317.9	65.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн	34.1	52.1	37.4	71.8	109.7

Тайлбар: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

Х.НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО,
ОЛГОСОН ТЭТГЭВЭРИЙН ХЭМЖЭЭ

2020.02.03

Үзүүлэлтүүд	2018 оны I сар	2019 оны I сар	2020 оны I сар	<u>2020 I</u> <u>2019 I</u> хувь
Заавал даатгуулагчийн тоо	2574	2870	3532	123.1
Үүнээс:				
Аж ахуй нэгж, байгууллага	484	791	444	56.1
Төсөвт байгууллага	1372	1321	934	70.7
Сайн дурын	718	758	2154	284.2
Олгосон тэтгэвэр, сая.төг	1890.3	2225.9	2523.5	113.4
Үүнээс:				
Өндөр настны	1556.9	1885.3	2129.0	112.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	218.9	205.9	242.7	117.9
Тэжээгчээ алдсаны	53.5	59.6	67.5	113.3
Цэргийн	61.0	75.1	84.3	112.3

XI. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2020.02.06

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
Дэлгэрцогт	0	0	1	0	0	0	0	0
Дэрэн	0	0	0	0	0	0	0	0
Говь-Угтаал	0	4	0	0	0	0	0	0
Цагаандэлгэр	0	0	0	0	0	0	0	0
Баянжаргалан	0	0	3	0	0	0	0	0
Өндөршил	0	0	0	1	0	0	0	0
Гурвансайхан	0	0	0	1	0	0	0	0
Өлзийт	2	2	0	2	0	0	0	0
Хулд	0	1	1	1	0	0	0	0
Луус	0	0	0	0	0	0	0	0
Дэлгэрхангай	2	1	0	0	0	0	0	0
Сайхан-Овоо	3	0	3	2	0	0	0	0
Эрдэнэдалай	0	2	4	2	0	0	0	0
Сайнцагаан	65	71	8	5	0	0	0	0
Адаацаг	0	0	0	2	0	0	0	0
Дүн	72	81	20	16	0	0	0	0

ЭМГ-н мэдээгээр

ХИИ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 1 сарын байдлаар
2020.02.06

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
									сүрьеэ		вируст гепатит	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
Дц	42	49	292	224	42	49	2	1	0	0	0	0
Дн	23	28	177	157	81	34	0	3	0	0	0	0
Гу	33	28	392	476	229	320	0	0	0	0	0	0
Цд	10	23	179	88	16	74	0	3	0	0	0	0
Бж	43	28	168	206	22	26	0	0	0	0	0	0
Өш	25	42	466	394	12	81	0	1	0	0	0	0
Гс	39	32	269	502	76	15	1	1	0	0	0	0
Өт	25	35	565	403	21	47	2	1	0	0	0	0
Хд	17	40	121	156	60	82	1	1	0	0	0	0
Лс	40	19	300	295	22	20	0	0	0	0	0	0
Дх	31	27	281	304	10	11	1	0	0	0	0	0
Со	23	30	66	117	21	53	1	0	0	0	0	0
Эд	50	83	867	844	264	310	2	3	0	0	0	0
Ад	33	47	746	363	30	58	1	1	1	1	0	0
Сц	542	628	11949	13303	2408	1333	50	24	1	0	0	0
Мд	53	50	33	48	0	0	0	0	0	0	0	0
Эб	54	43	34	49	0	0	0	0	0	0	0	0
МУЭ төв	81	81	177	206	50	116	0	0	0	0	0	0
ДҮН	1164	1313	17082	18135	3364	2629	61	39	2	1	0	0

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

ХИИ. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2020.02.06

	2020 I 2019 I	2020 I 2019 XII
ЕРӨНХИЙ ИНДЕКС	107.7	100.9
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	113.4	102.0
01.1 ХҮНСНИЙ БАРАА	114.7	102.2
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	119.6	100.7
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	118.2	108.6
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН	122.7	100.0
01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	112.4	100.0
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	104.4	100.2
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	119.9	100.0
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	106.1	100.2
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	102.4	100.5
01.1.9 ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН	105.2	100.0
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	98.5	99.7
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	104.8	100.0
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	104.7	100.1
02.2 ТАМХИ	105.0	100.0
03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ	109.9	101.2
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	111.0	101.7
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	124.1	106.0
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	109.5	101.1
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	104.9	100.0
03.2 ГУТАЛ	107.4	100.0
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	105.5	100.2
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	100.0	100.0
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	109.6	100.8
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	104.8	100.0

Барааны бүлгээр		2020 I 2019 I	2020 I 2019 XII
05.	ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	108.3	101.1
	05.1 ГЭР АХУЙН ТАВИЛАГ, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	112.8	102.6
	05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	106.4	100.0
	05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	102.0	100.0
	05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	109.8	100.0
	05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРС	101.1	100.4
	05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУ	107.8	100.5
06.	ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.2	100.6
	06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ	101.4	100.7
	06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
07.	ТЭЭВЭР	101.2	100.0
	07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	101.9	100.0
	07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.2	100.0
08.	ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	08.2 ТЕЛЕФОН АППАРАТ, ФАКСЫН ХЭРЭГСЭЛ	100.0	100.0
	08.3 ТЕЛЕФОН УТАС, ФАКСЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
09.	АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	103.1	100.0
	09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨР	102.3	100.0
	09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.3	100.0
	09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	105.9	100.0
10.	БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	111.4	100.0
11.	ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	136.2	109.4
	11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	115.5	100.0
	11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	148.1	114.3
12.	БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	105.1	100.0
	12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	105.6	100.0
	12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	105.1	100.0
	12.5 ДААТГАЛ	100.0	100.0
	12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

XIV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 1-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/
2020.02.06

	Нэр төрөл	Дундговь	Төв	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	1567.0	1406.0	1567.0	1433.0
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	1293.0	1210.0	1360.0	1133.0
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	975.0	913.0	1200.0	925.0
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	860.0	750.0	1750.0	817.0
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	1183.0	1333.0	1217.0	1567.0
6	Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/	3167.0	1300.0	2400.0	2067.0
7	Жигнэмэг /Юбилейные 150-180г, цайны/	1233.0	1300.0	1267.0	1250.0
8	Цагаан будаа, задгай, кг	2367.0	2666.0	2267.0	2267.0
9	Шар будаа, задгай, кг	3325.0	3150.0	3140.0	3233.0
10	Хонины мах, кг	7500.0	8000.0	6500.0	7000.0
11	Адууны мах, кг	8000.0	8000.0	7500.0	8000.0
12	Ямааны мах, кг	6500.0	6500.0	5500.0	5833.0
13	Дотор мах, цувдай, цусгүй	2500.0	3167.0	2750.0	2500.0
14	Хиам чанасан, 1кг	9533.0	12572.0	11500.0	8100.0
15	Сүү, задгай, л	3500.0	2000.0	4000.0	2500.0
16	Сүү савласан,1л. Цэвэр сүү	2967.0	3080.0	2890.0	3000.0
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	28000.0	16285.0	15000.0	16333.0
18	Өндөг,ш,дотоод	380.0	363.0	357.0	387.0
19	Ургамлын тос, 1литр, Кларина	3730.0	3916.0	3350.0	3300.0
20	Өөхөн тос, кг	-	1400.0	-	1500.0
21	Шар тос, кг	20000.0	20531.0	18000.0	18333.0
22	Цөцгийн тос, задгай, кг	-	4000.0	3850.0	3500.0
23	Төмс дотоод, кг	930.0	866.0	1450.0	1000.0
24	Лууван хятад, кг	1267.0	1800.0	1450.0	1633.0
25	Байцаа хятад, кг	1533.0	1826.0	1200.0	1700.0
26	Сонгино хятад, кг	1467.0	1800.0	1600.0	1633.0
27	Элсэн чихэр, кг, орос	1967.0	2066.0	2100.0	2000.0
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	5650.0	5533.0	3720.0	5900.0
29	Зөөлөн чихэр, /Мишка/, кг	-	-	-	-
30	Шоколад, "Alpen gold"	2493.0	2513.0	2257.0	2300.0
31	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	1067.0	996.0	833.0	750.0
32	Майноз, /Золотой 500г/	-	5250.0	3797.0	5150.0
33	Кетчуп, 900г, Чили Полиш	2000.0	1900.0	2050.0	2000.0
34	Ногоон цай, Stimo, савласан 90г	1550.0	1733.0	1413.0	-
35	Байхуу цай, Акбар, 20 ширхэгтэй	1667.0	1733.0	1597.0	1600.0
36	Цагаан архи, 0.5 Ерөөл	8700.0	8833.0	8933.0	9133.0
37	Пиво, "Боргио", 0.5л	1700.0	1766.0	1750.0	1825.0
38	Янжуур тамхи, /West/, саарал	3133.0	2833.0	2933.0	2700.0
39	Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи	2200.0	2043.0	2133.0	1900.0
40	Бензин, А-80, 1 литр	1810.0	1730.0	1850.0	1810.0
41	Бензин, А-92, 1 литр	1920.0	1770.0	1960.0	1910.0
42	Дизель түлш, 1 литр	2490.0	2360.0	2490.0	2560.0

XV. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

2020.2.10

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019 оны мөн үед	2020 онд	2019/2018 хувь
Хүрэн нүүрс	мян.тн	3.0	3.3	110.0
Жонш	мян.тн	0.0	0.2	-
Гөлтгөнө	мян.тн	0.0	0.0	-
Дулааны эрчим хүч	мян.гкал	16.5	18.7	113.3
Хүснэгт, маягт	х.д.х	12.1	17.9	147.9
Талх	тн	7.7	10.5	136.4
Нарийн боов	тн	14.3	10.3	72.0
Чихэр	тн	0.5	0.4	80.0
Архи	мян.л	2.6	1.7	65.4
Хиамны зүйл	тн	0.3	0.3	100.0
Сүү, тараг	мян.л	0.1	0.3	300.0
Хоормог	мян.л	0.0	0.0	-
Ааруул	тн	0.3	0.0	0.0
Вакум цонх	м ²	0.0	0.0	-
Вакум хаалга	м ²	0.0	0.0	-
Модон эдлэл	мян.төг	22450.0	41268.0	183.8
Түгээсэн цэвэр ус	мян.т ³	10.6	10.4	98.1
Сувагжуулалт	мян.м ³	7.1	6.9	97.2
Оёдол эсгүүр	мян.төг	5665.0	3270.0	57.7
Блок	мян.ш	0.0	0.0	-

XVI. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр)

2020.02.10

МЯН.ТӨГ

Аж үйлдвэрийн салбар	2019	2020	2020/2019 хувь
Нийт дүн	789257.6	904596.1	114.6
Уул уурхайн олборлох аж үйлдвэр	85162.0	134470.0	157.9
Нүүрс олборлолт	85162.0	92470.0	108.6
Гөлтгөнө	0.0	0.0	-
Жонш олборлолт	0.0	42000.0	-
Боловсруулах аж үйлдвэр	112877.7	125931.0	111.6
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	105586.5	80496.4	76.2
Хуснэгт маягт үйлдвэрлэл	846.2	1256.6	148.5
Боловсруулах үйлдвэр бусад	6445.0	44178.0	685.5
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	591217.9	644195.1	109.0
<i>Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл</i>	532816.7	586961.3	110.2
Ус ариутгал ус хангамж	58401.2	57233.8	98.0

**XVII.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ, 2020 оны 01 сарын байдлаар
МЯН.ТӨГ**

2020.02.06

Халамжийн төрөл	хамрагдсан хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн тэтгэвэр		
<i>мөр(42)=мөр(43:47)</i>	717	145,169
Ахмад настны тэтгэвэр	44	7,504
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	476	85,782
Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	197	51,882
Нийгмийн халамжийн тэтгэмж		
<i>мөр(48)=мөр(49+59+60)</i>	928	90,528
<i>Асаргааны тэтгэмж</i>	781	65,333
<i>Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний</i>	26	2,471
<i>Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний</i>	2	380
<i>Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний</i>		
<i>мөр(52)=мөр(53+54)</i>	3	228
<i>Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэний</i>	3	228
<i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэртээ асрамжилж байгаа иргэний</i>		
<i>Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэний</i>		
<i>мөр(55)=мөр(56+57+58)</i>	750	62,253
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа</i>	140	10,888
<i>Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний</i>	462	35,045
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа</i>	148	16,320
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж		
<i>мөр(60)=мөр(61:66)</i>	147	25,195
<i>Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх</i>	1	1,200
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд</i>	146	23,995
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн</i>		
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	17	2,358
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	24	3,908
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	30	1,892
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж		
<i>мөр(88)=мөр(89:92)</i>	2192	105358.3
<i>0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж</i>	1767	88728.9
<i>Жирэмсэн эхийн тэтгэмж</i>	425	16629.4
Нийт	3,908	349,212

XVIII. ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

2020.02.06

сум	18 ба түүнээс дээш насны ХҮН	18-аас дээш насны 10000 ХҮНД НОГДОХ	Бүх хэрэг	Холбогдогч	Хохирол /мян.төг/	Золгүй учрал	Хүн амь	хүчин	дээрэм	булаалт	танхай	бусдын бие махбодьд гэмтэл	бусдын өмчийн хулгай	малын хулгай	Тээврийн хэрэгс-лийн гал түймэр	албан тушаал	Залилан	бусад	
Адаацаг	1836	5	1		1000.0								1						
Баянжаргалан	809	25	2		19000.0							1						1	
Говь-Угтаал	1047	10	1		15000.0													1	
Гурвансайхан	1455	27	4		3000.0							1		1				2	
Дэлгэрхангай	1471	0	0																
Дэлгэрцогт	1096	9	1		3000.0							1							
Дэрэн	1368	0	0																
Луус	1235	0	0																
Өлзийт	1586	25	4		22000.0									1				3	
Өндөршил	961	10	1															1	
Сайнцагаан	10013	23	23	1	68101.0			2	2			9	4		1		4	1	
Сайхан-Овоо	1406	7	1																
Хулд	1554	0	0																
Цагаандэлгэр	684	29	2		2650.0							1		1					
Эрдэнэдалай	3662	3	1		300.0							1							
Бусад	0																		
Бүгд	30183	14	41	1	134051.0	1	0	2	2	0	0	14	5	3	1	0	0	4	9

XIX. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ

2020.02.06

Үзүүлэлт		2019 I	2020 I	20/19 хувь
Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо		30616	30183	98.6
Хэргийн өнгө	Бүх хэрэг	25	41	164.0
	Хүнийг санаатай алах гэмт хэрэг	0	0	0.0
	Хүчиндэх гэмт хэрэг	0	2	0.0
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	1	1	0.0
	Дээрэмдэх гэмт хэрэг	0	2	0.0
	Булаалт	0	0	0.0
	Танхайн хэрэг	0	0	0.0
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	6	14	233.3
	Бусдын эд хөрөнгийн хулгай	5	5	100.0
	Малын хулгай	5	3	60.0
	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	2	1	50.0
	Залилангийн хэрэг	2	4	200.0
	Албан тушаал	0	0	0.0
	Бусад	4	9	225.0
нөхцөл	Эмэгтэй хүн оролцсон	0	3	0.0
	Согтуугаар	3	0	0.0
	Бүлэглэж	4	7	175.0
	Хүүхэд оролцсон	1	0	0.0
	Илрээгүй хэрэг	19	39	205.3
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	0	0	0.0	
хэргийн ангилал	Хөнгөн	18	37	205.6
	Хүндэвтэр	0	0	0.0
	Хүнд	7	4	57.1
	Онц хүнд	0	0	0.0
Гэмт хэрэгт холбогдогсод		5	1	20.0
Учирсан бүх хохирол /сая.төг/		50.2	134.1	267.1
Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/		0.0	0.0	0.0
Илрүүлэлтийн хувь		13.6	2.5	18.4
18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/		8	14	166.4

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

www.1212.mn



Дундговь аймгийн
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



www.dundgovi.nso.mn

Материалыг бэлтгэсэн:

**Т.Бямбасүрэн
Г.Ариунжаргал
Н.Түвшинжаргал**

Утас 70593714, 70593715

2020 оны 02 сарын 12

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Б.ЭНХТУЯА